

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ...	7
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3. Менежментийн захидал	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	14
4.3 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
УЗ	Удирдах зөвлөл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН
ЗАХИРГААНЫ ДАРГА С.ТҮВШИНТӨР
ТАНАА

2020.03.13 № 06/799
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол улсын далайн захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол улсын далайн захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол улсын далайн захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Монгол улсын далайн захиргаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Монгол улсын далайн захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монгол улсын далайн захиргааны дарга С.Түвшинтөр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн татвар, нийгмийн даатгалын байгууллагатай авлага, өглөгийн тооцоо нийлж байх, үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоололд тавих хяналтыг сайжруулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, санхүүгийн программ хангамжийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол улсын далайн захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Монгол улсын далайн захиргааны 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Монгол улсын далайн захиргааны удирдлага нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль дагуу болон НББОУС түүнд нийцүүлэн баталсан аж ахуй нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ийн ерөнхий захирал Д.Түмэнжаргал, чанарын хяналтын менежер Д.Нямдорж, аудитор Р.Цанжидмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол улсын далайн захиргааны 2019 оны санхүүгийн тайланг “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол улсын далайн захиргааны зорилго нь “Далайн тээврийн салбарын эрх зүйн орчин, хяналтын системийг боловсронгуй болгох, олон улсын стандартад нийцүүлэх, далайн тээврийн салбарт тэргүүлэгч улсуудтай хамтран далайн тээвэр эрхлэх боломжийг эрэлхийлэх, Нэгдсэн үндэсний байгууллагын далайн гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын судалгааны төвтэй хамтран ажиллах, усан замын тээврийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, сурталчлах, байгаль орчинд ээлтэй усан замын тээврийг хөгжүүлэх, аюулгүй байдлыг хангах” гэж тодорхойлсон байна.

Монгол улсын далайн захиргаа нь “Далайн тээврийн олон улсын гэрээ, конвенц болон дотоодын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, далайн тээврийн стратеги, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохицуулах, далайн чиглэлээр боловсон хүчин бэлтгэх, хөлөг онгоц бүртгэх, боомт ашиглах, усан замын тээврийн бүртгэл хийх, хяналт тавих” гэж үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд татварын хөнгөлөлт
- Нийгмийн даатгалын тухай хуульд шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орсныг хэрэгжүүлж ажилласан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Монгол улсын далайн захиргаа нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Ординат” ХХК-ийн боловсруулсан “Unicus1.1” санхүүгийн программ хангамжийг ашигладаг байна.

Монгол улсын далайн захиргаа нь дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Монгол улсын далайн захиргааны бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 26 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,089.9 сая төгрөгөөс тооцон 10.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 12.9 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Монгол улсын далайн захиргааны 2019 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 960.2 сая төгрөгөөр буюу 59.8 хувиар өссөн байна. Мөнгөн хөрөнгө, бараа материал, урьдчилж төлсөн зардал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	/сая.төгрөг/		
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
1	Мөнгөн хөрөнгө	574.9	1,239.4	664.5
2	Бараа материал	47.9	62.5	14.7
3	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	367.2	562.4	195.2
4	Үндсэн хөрөнгө	411.1	497.0	85.9
5	Биет бус хөрөнгө	12.4	12.4	-
6	Урт хугацаат хөрөнгө оруулалт	190.2	190.2	-
7	Нийт хөрөнгө	1,603.7	2,564.0	960.2
8	Эздийн өмч	231.2	231.2	-
9	- төрийн	231.2	231.2	-
10	Хуримтлагдсан ашиг	1,372.6	2,332.8	960.2
11	Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,603.7	2,564.0	960.2

Мөнгөн хөрөнгийн өссөн нь орлогын төлөвлөгөө 53.9 сая төгрөгөөр давсан, 1,104.1 сая төгрөгийн төсөвлөсөн зардлыг дутуу зарцуулсан үлдэгдлээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдлийн өөрчлөлт нь худалдаж авсан 42.5 сая төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагаанд зарцуулсан 27.8 сая төгрөгөөр хасагдсантай холбоотой байна.

Урьдчилж төлсөн зардал, тооцоо дансны үлдэгдлийн өөрчлөлт нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 58 дугаар тушаалаар баталсан Далайн захиргааны 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу “Хөвсгөл аймгийн Ханх суманд Усан замын тээврийн хяналтын байр, хашаа, ариун цэврийн байгууламжийн барилга барих ажил, Хатгал тосгонд Усан замын тээврийн хяналтын байрны хашаа, харуулын байрны барилга барих ажлын хүрээнд нийт 195.2 сая төгрөгийн дараах зардлуудыг урьдчилж төлснөөс шалтгаалжээ. Үүнд:

- Хатгал, Ханх суманд хяналтын байр барих тендерийн зураг төсөл, төсөв, хөрсний судалгааны ажлын төлбөрт “Барт төсөл” ХХК-д 3.6 сая төгрөг,
- Барилгын хөрсний судалгаа “Ленд тест” ХХК-д 4.5 сая,
- Барилгын ажлын урьдчилгаа “Гэрэгэ дизайн констракшн” ХХК-д 184.6 сая төгрөг,
- Төсвийн зардалд иргэн Г.Алтансүвд 0.5 сая төгрөг,
- Захиалагчийн хяналт Хөвсгөл аймгийн ГХБХБГ-т 2.0 сая төгрөг

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийн өөрчлөлт нь өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 171.8 сая төгрөгөөр нэмэгдэж, элэгдлийн зардал 86.0 сая төгрөгөөр хасагдсантай холбоотой буюу үндсэн хөрөнгө нийт дүнгээр 20.9 хувиар буюу 85.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын 2015 оны 180 дугаар тогтоолоор “Зам, тээврийн яамны харьяа Далайн захиргаа болон БНСУ-ын далайн тээврийн компанийн хөрөнгө оруулалттай БНСУ-д бүртгэлтэй далайн тээврийн хамтарсан компани байгуулахыг Зам, тээврийн яам болон Төрийн өмчийн САГ-2020/113/СТА-ТӨҮГ

хороонд зөвшөөрсөн байна. Монгол Сингапурын хамтарсан “Монголын хөлөг онгоцны бүртгэл” ХК-аас БНСУ-д бүртгэлтэй “Монгол-Саммок Ложистик” хамтарсан компанийн байгуулахад 190.2 сая төгрөгийг хөрөнгө оруулж, Далайн захиргааны 2015 оны санхүүгийн тайланд тусгаж, тайлагнуулжээ.

Эздийн өмч дансны үлдэгдэл 2,564.0 сая төгрөг болж 960.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үйл ажиллагааны ашгаас шалтгаалжээ.

2.9. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол улсын далайн захиргаа нь 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар улсын төсөвт орлого төвлөрүүлэх 209.0 сая төгрөгийн төлөвлөгөө батлагдаж, гүйцэтгэлээр 210.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 100.5 хувиар биелүүлжээ.

2019 оны улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг доорх хүснэгтээр харуулав.

/сая. төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Төвлөрүүлэх орлого	209.0	210.0	(10.0)	100.5
Нийт дүн	209.0	210.0	(10.0)	100.5

Монгол улсын Далайн захиргааны 2019 оны орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Монгол Улсын Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 58 дугаар тушаалаар баталжээ.

2019 оны төсөв төлөвлөгөө, гүйцэтгэлийг доорх хүснэгтээр харуулав.

/сая төгрөг/

Үзүүлэлт	2019 он		Өөрчлөлт	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Нийт орлого	2,304.4	2,250.5	(53.9)	97.7
Нийт зардал	2,304.4	1,290.3	(1,014.1)	55.9
Тайлант үеийн ашиг	-	960.2	960.2	960.2

Тайлант онд байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан нийт зардлын 1,641.6 сая төгрөгийг хөлөг онгоцны бүртгэлийн хураамжаас, 657.8 сая төгрөгийг хувьцааны ногдол ашгаас, 5.0 сая төгрөгийг бусад орлогоос нийт 2,304.4 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр хөлөг онгоцны бүртгэлийн хураамжаас 1,501.9 сая, хувьцааны ногдол ашгаас 685.0 сая, хүүгийн орлого 18.3 сая, бусад орлого 45.5 сая, нийт 2,250.5 сая төгрөгийн бүрдсэн байна.

Нийт орлого нь төлөвлөгөөнөөс 97.7 хувиар буюу 53.9 сая төгрөгөөр тасарсан нь Монгол Сингапурын хамтарсан “Монголын хөлөг онгоцны бүртгэл” ХХК нь 2019 оны 11,12 сарын үйл ажиллагааны зардлын санхүүжилтийг олгоогүйгээс шалтгаалжээ.

Үндсэн үйл ажиллагааны зардалд 2,304.4 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,290.3 сая төгрөгийн биелэлттэй ажиллаж, 1,014.1 сая төгрөгөөр зардлыг хэмнэсэн нь Хөвсгөл аймгийн Ханх суманд Усан замын тээврийн хяналтын байр, хашаа, ариун цэврийн байгууламжийн барилга барих ажил, Хатгал тосгонд Усан замын тээврийн хяналтын байрны хашаа, харуулын байрны барилга барих ажил, Усан замын тээврийн салбарын хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлох, төрөөс усан замын тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах ажил, Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын стандарт, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах ажлууд 2019-2020 он дамжин хэрэгжихээр болсон болон үндсэн болон нэмэгдэл цалин, шимтгэлийн зардлыг 108.3 сая, тээвэр шатахууны зардлын 29.6 сая, шуудан холбооны зардлыг 14.4 сая, албан томилолтын зардлыг 82.7 сая төгрөгөөр хэмнэснээс шалтгаалжээ.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 26 эрсдэл тогтоож, гүйцэтгэх үе шатанд 26 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 18.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 6.8 сая төгрөгийн алдааг залруулж, 8.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд албан шаардлага, 2.8 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнд:

- Ажил үйлчилгээ гүйцэтгэх гэрээ, гэрээ дүгнэсэн баримтгүйгээр “Монголоо” ХХК-ийн нэхэмжлэлээр байгууллагын ажилтан 3.4 сая төгрөгийг бэлнээр, “Шижир тайш консалтинг” ХХК-д 3.4 сая төгрөгийг шилжүүлсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, 20 дугаар зүйлийн 20.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна”, 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад баримтын бүрдүүлж, зөрчлийг арилгуулсан.

- Байгууллагын эрх бүхий албан тушаалтан өөртөө тушаал гаргаж 8.8 сая төгрөгийн буцалтгүй тусламж авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2-д “төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 58 дугаар тушаалаар баталсан Монгол Улсын далайн захиргааны 2019 оны орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан орлогын төлөвлөгөө тасарсан, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-ийн 1/3-д “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”, заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн 2.8 сая төгрөгийн алдаа болон бусад зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Монгол улсын далайн захиргаа нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасны дагуу 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар болон shilendans.gov.mn нэгдсэн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Монгол улсын далайн захиргаа нь шилэн дансны нэгдсэн цахим системд 2019 онд 13 нэр төрлийн мэдээллийг жил, сар бүрийн давтамжтайгаар 146 удаа мэдээлэхээс 144 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 2 мэдээллийг хугацаа хожимдуулж мэдээлсэн байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1.9 сая төгрөгийн 1 албан шаардлага, 0.1 сая төгрөгийн 1 төлбөр акт, 0.06 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн байна.

Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол улсын далайн захиргааны 2019 оны санхүүгийн тайлан тодруулгад аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 11.6 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 12.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Монгол улсын далайн захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын байгууллагаас олгосон урамшууллын 0.6 сая төгрөгийг орлого, авлагыг бүртгэж тайлагнаагүй, татвар, нийгмийн даатгалын байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй. Энэ нь хэмжилт, үнэн зөв байдал, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу гарах, авлага, өглөг баталгаажаагүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Татвар, нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлж, авлага, өглөгийг үнэн зөв бүртгэж тайлагнах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг албан бичгээр ирүүлсэн.

3.2. Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Тээврийн хэрэгслийн элэгдэл тооцох хугацааг НБББББ-д заасан хугацаанаас зөрүүтэй тооцоож 2.2 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” заалтыг зөрчсөн.

3.2.2 Эрсдэл:

Хууль, заавар журам хэрэгжихгүй байх, санхүүгийн тайлан буруу гарах.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн элэгдлийг холбогдох заавар журмын дагуу тооцож, үнэн зөв бүртгэж тайлагнах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг албан бичгээр ирүүлсэн.

3. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.3.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн байгууллагын онцлог, үйл ажиллагаатай уялдаж байгаа хэдий ч Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас гаргасан заавар, журмын дагуу шинэчлэгдээгүй. Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, хэмжилт, үнэлгээ зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм журам зааварт нийцүүлэн НБББББ-ийг баталж мөрдөн ажиллана” заалтыг зөрчсөн.

3.3.2. Эрсдэл:

Хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан заавар, журам зөрчигдөх.

3.3.3. Өгсөн зөвлөмж:

НБББББ-ийг хууль тогтоомж, стандарт, заавар, журамд нийцүүлэн шинэчилж байх.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг албан бичгээр ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	989,975,195.33	1,864,352,136.08
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	574,861,537.72	1,239,397,832.82
3102	Банканд байгаа бэлэн мөнгө	574,861,537.72	1,239,397,832.82
310201	Төгрөг	355,688,542.94	388,158,383.36
31020103	Арилжааны банк дахь харилцах	355,688,542.94	388,158,383.36
31220	Гадаад валют	219,172,994.78	851,239,449.46
31020203	Арилжааны банк дахь харилцах	219,172,994.78	851,239,449.46
33	АВЛАГА	32,610.46	32,610.46
3301	Ажиллагчидтай холбогдсон авлага	32,610.46	32,610.46
34	УРЬДЧИЛГАА	367,224,643.30	562,374,921.3
3406	Урьдчилж гарсан зардал	282,000.00	282,000.00
3407	Урьдчилгаа тооцоо	366,942,643.30	562,092,921.30
340702	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	366,942,643.30	562,092,921.30
35	БАРАА МАТЕРИАЛ	47,856,403.85	62,546,771.50
3504	Хангамжийн материал	47,856,403.85	62,546,771.50
3504010	Бичиг хэргийн материал	4,057,797.85	3,818,252.50
3504020	Аж ахуйн материал	42,195,612.00	45,896,212.00
350404	Түлш, шатах тослох материал	-	175,536.00
350407	Бусад хангамжийн материал	1,602,994.00	12,656,771.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	613,746,228.49	699,606,661.21
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	190,192,000.00	190,192,000.00
3703	Урт хугацаат зээл	190,192,000.00	190,192,000.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	423,554,228.49	509,414,661.21
3902	Биет хөрөнгө	411,106,228.49	496,966,661.21
390201	Барилга, байгууламж, орон сууц	52,895,760.04	52,895,760.04
39020101	Хуримтлагдсан элэгдэл	-	1,811,076.72
390202	Авто-тээврийн хэрэгсэл	454,840,201.74	577,840,201.74
39020201	Хуримтлагдсан элэгдэл	146,528,405.43	216,594,500.64
390203	Машин тоног төхөөрөмж (компьютер)	86,017,316.01	125,707,388.01
39020301	Хуримтлагдсан элэгдэл	52,619,717.19	64,185,489.14
390204	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,742,169.00	40,894,069.00
39020401	Хуримтлагдсан элэгдэл	15,241,095.68	17,779,691.08
3903	Биет бус хөрөнгө	12,448,000.00	12,448,000.00
390301	Программ хангамж	5,460,000.00	5,460,000.00
39030101	Хуримтлагдсан элэгдэл	5,460,000.00	5,460,000.00
390302	Бусад биет бус хөрөнгө	12,448,000.00	12,448,000.00
399	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,603,721,423.82	2,563,958,797.29
4101	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
519	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,603,721,423.82	2,563,958,797.29
5	Засгийн газрын хувь оролцоо	1,603,721,423.82	231,164,305.84

Монгол Улсын далайн захиргааны 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

5101	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	231,164,305.84	231,164,305.84
510101	Өмч:- төрийн	218,716,305.84	231,164,305.84
510102	Эздийн өмчийн бусад хэсэг	12,448,000.00	-
5102	Хуримтлагдсан үр дүн	1,372,494,657.98	2,332,732,031.45
510201	Өмнөх үеийн үр дүн	1,026,456,034.49	1,372,494,657.98
510202	Тайлант үеийн үр дүн	346,038,623.49	960,237,373.47
5103	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	62,460.00	62,460.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,603,721,423.82	2,563,958,797.29

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,403,803,961.32	2,215,155,145.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,403,803,961.32	2,215,155,145.98
120	Нийтлэг татварын бус орлого	1,403,803,961.32	2,215,155,145.98
120001	Хувьцааны ногдол ашиг	-	684,972,253.90
120002	Хүүгийн орлого	10,988,815.59	18,298,438.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,387,653,849.73	1,501,930,083.18
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	867,075,669.53	1,236,861,662.55
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	520,578,180.20	265,068,420.63
120009	Бусад орлого	5,161,296.00	9,954,370.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,042,307,036.43	1,284,709,421.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,042,307,036.43	1,284,709,421.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	833,307,036.43	1,074,709,421.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	436,251,750.34	546,711,864.94
210101	Үндсэн цалин	364,619,797.69	459,500,535.51
210102	Нэмэгдэл	53512452.65	68,167,829.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,119,500.00	19,043,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,673,158.83	68,668,603.38
210201	Тэтгэврийн даатгал	35,634,540.02	47,304,056.51
210202	Тэтгэмжийн даатгал	4,384,117.47	5,461,465.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,508,143.55	4,369,172.36
210204	Ажилгүйдлийн даатгал	831,487.03	1,048,537.17
210205	Эрүүл мэндийн даатгал	8,314,870.76	10,485,371.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,757,200.00	51,026,800.00
210304	Байрны түрээс	42,757,200.00	51,026,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,143,150.21	40,211,310.83
210401	Бичиг хэрэг	2,183,582.15	3,468,445.35
210402	Тээвэр, шатахуун	16,134,059.00	26,391,429.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,825,509.06	10,351,436.48
2107	Томилолт, зочны зардал	128287,307.20	105,071,136.31
210701	Гадаад албан томилолт	117,829,927.20	85,759,657.31
210702	Дотоод албан томилолт	9,667,380.00	10,108,734.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	790,000.00	9,202,745.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	132,530.35	214,502.02
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	132,530.35	214,502.02
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	147,061,939.50	262,805,204.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86,849,540.00	176,823,665.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,212,399.50	85,981,539.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	209,000,000.00	210,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	209,000,000.00	210,000,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	209,000,000.00	210,000,000.00

Монгол Улсын далайн захиргааны 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	361,496,924.89	930,445,724.22
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	32,156,551.46	35,392,822.35
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	32,156,551.46	35,392,822.35
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	47,614,852.86	5,601,173.10
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	7,608,824.46	5,601,173.10
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	40,006,028.40	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-15,458,301.40	960,237,373.47
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	346,038,623.49	960,237,373.47

4.3 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,517,656,424.32	2,221,867,275.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,504,080,354.32	2,220,950,389.37
120	Нийтлэг татварын бус орлого	1,504,080,354.32	2,220,950,389.37
120001	Хувьцааны ногдол ашиг	0.00	684,972,253.90
120002	Хүүгийн орлого	10,988,815.59	18,298,438.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,387,653,849.73	1,501,930,083.18
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	867,075,669.53	955,704,677.85
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	520,578,180.20	546,225,405.33
120009	Бусад орлого	105,437,689.00	15,749,613.39
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,576,070.00	916,886.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,576,070.00	916,886.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	13,576,070.00	916,886.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,360,124,320.28	1,415,280,657.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,360,124,320.28	1,415,280,657.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,119,016,250.28	1,189,780,171.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	434,259,854.42	546,365,979.95
210101	Үндсэн цалин	367,855,749.16	461,941,014.17
210102	Нэмэгдэл	48,284,605.26	65,381,465.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,119,500.00	19,043,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,673,158.95	68,668,603.37
210201	Тэтгэврийн даатгал	52,673,158.95	68,668,603.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,531,700.00	51,139,800.00
210304	Байрны түрээс	42,531,700.00	51,139,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,067,848.06	38,972,576.48
210401	Бичиг хэрэг	3,021,380.00	3,257,900.00
210402	Тээвэр, шатахуун	15,762,059.00	25,363,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,064,409.06	10,351,436.48
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	220,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	137,533,008.20	107,522,018.70
210701	Гадаад албан томилолт	125,638,628.20	86,270,234.70
210702	Дотоод албан томилолт	11,104,380.00	13,194,089.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	790,000.00	8,057,695.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	424,950,680.65	377,111,193.02
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	423,358,516.30	353,739,550.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	7,850,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	77,220.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	354,214.00	510,641.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	46,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	14,750,000.00

Монгол Улсын далайн захиргааны 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	140,730.35	215,002.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	241,108,070.00	225,500,486.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,108,070.00	15,500,486.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	13,576,070.00	916,886.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	117,000.00	90,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,400,000.00	8,820,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,015,000.00	5,673,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	209,000,000.00	210,000,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	209,000,000.00	210,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	157,532,104.04	806,586,617.85
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	32,156,551.46	35,392,822.35
145001	Валютын ханшийн зөрүү	32,156,551.46	35,392,822.35
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	157,552,207.24	171,841,972.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	157,552,207.24	171,841,972.00
2200	Дотоод эх үүсвэрээр	157,552,207.24	171,841,972.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	157,552,207.24	171,841,972.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-133,004,480.24	-136,449,149.65
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-125,395,655.78	-5,601,173.10
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-7,608,824.46	5,601,173.10
25	ГАДААД ВАЛЮТЫН ХАНШНЫ ЗӨРҮҮ	-7,608,824.46	5,601,173.10
250001	Гадаад валютын ханшны зөрүү	-7,608,824.46	5,601,173.10
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	24,527,623.80	664,536,295.10
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	550,333,913.92	574,861,537.72
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	574,861,537.72	1,239,397,832.82

4.4 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,716,305.84		1,026,456,034.49	1,245,172,340.33
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	12,448,000.00			12,448,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	231,164,305.84		1,026,456,034.49	1,257,620,340.33
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	62,460.00	-	62,460.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-		-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-	-
Тайлант үеийн үр дүн	-		346,038,623.49	346,038,623.49
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	231,164,305.84	62,460.00	1,372,494,657.98	1,603,721,423.82
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	231,164,305.84	62,460.00	1,372,494,657.98	1,603,721,423.82
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-		-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-		-	-
Тайлант үеийн үр дүн	-		960,237,373.47	960,237,373.47
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	231,164,305.84	62,460.00	2,332,732,031.45	2,563,958,797.29

4.5 Аудит хийгдсэн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн тайлан

мянган. төгрөг

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого	2,304,459.1	2,250,547.9	53,911.1	97.6
Үүнээс	Хөлөг онгоцны бүртгэлийн хураамж	1,641,659.1	1,501,930.0	139,729.0	91.4
	Хувьцааны ногдол ашиг	657,800.0	684,972.2	(27,172.2)	104.1
	Хүүгийн орлого		18,298.4	(18,298.4)	
	Бусад орлого	5,000.0	45,347.1	(40,347.1)	906.9
2	Нийт зардал	2,304,459.1	1,290,310.5	1,014,148.5	55.9
3	Цэвэр ашиг /алдагдал/	-	960,237.3	(960,237.3)	
4	Төсвийн төлбөрт нийт дүн	81,833.5	69,179.2	12,654.2	84.5
	в/ НДШ	81,833.5	68,668.6	13,164.9	83.9
	ё/ Тээврийн хэрэгслийн татвар	-	510.6	(510.6)	
5	Нийт ажиллагсдын тоо	27	27	-	
6	Нийт цалингийн сан	654,668.0	546,365.9	108,302.0	83.4
7	Нэг ажиллагчийн дундаж цалин	2,020.5	1,686.3	334.27	83.4
8	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	1.0	1.0	-	-
9	Хөрөнгө оруулалт	663,783.3	171,841.9	491,941.33	25.8
10	Нийт авлага	32.6	32.6	-	-

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Монгол Улсын далайн захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2019.12.31			САГ-2020/113/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Монгол Улсын далайн захиргаа ТӨҮГ		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн сая.төг	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Нийгмийн даатгалын байгууллагаас олгосон урамшууллын 0.6 сая төгрөгийг орлого, авлагыг бүртгэж тайлагнаагүй, татвар, нийгмийн даатгалын байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй.	0.6	Зөвлөмж өгөх	Дарга, Нягтлан бодогч	С.Түвшинтөр, П.Мөнхбат
2	Тээврийн хэрэгслийн элэгдэл тооцох хугацааг НБББББ-д заасан хугацаанаас зөрүүтэй тооцож 2.2 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан.	2.2	Зөвлөмж өгөх	Дарга, Нягтлан бодогч	С.Түвшинтөр, П.Мөнхбат
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн байгууллагын онцлог, үйл ажиллагаатай уялдаж байгаа хэдий ч Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас гаргасан заавар, журмын дагуу шинэчлэгдээгүй.	-	Зөвлөмж өгөх	Дарга, Нягтлан бодогч	С.Түвшинтөр, П.Мөнхбат
4	Байгууллагын эрх бүхий албан тушаалтан өөртөө тушаал гаргаж 8.8 сая төгрөгийн буцалтгүй тусламж авсан.	8.8	Төлбөрийн акт тогтоох	Дарга, Нягтлан бодогч	С.Түвшинтөр, П.Мөнхбат
5	Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 58 дугаар тушаалаар баталсан Монгол Улсын далайн захиргааны 2019 оны орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан орлогын төлөвлөгөө тасарсан, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна	-	Албан шаардлага хүргүүлэх	Дарга, Нягтлан бодогч	С.Түвшинтөр, П.Мөнхбат
	Дүн	11.6			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 03 дугаар сарын 18

№ 02/62

Улаанбаатар хот

СМГ-2020/113/СТА-ТӨЧГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Монгол Улсын далайн захиргаа" ТӨҮГ-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

• Байгууллагын эрх бүхий албан тушаалтан өөртөө тушаал гаргаж 8,820,000.00 /Найман сая найман зуун хорин мянган/ төгрөгийн буцалтгүй тусламж авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2 "төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх" Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-т заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Зөрчлийн нийт 8,820,000.00 /Найман сая найман зуун хорин мянган/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Улсын төсвийн орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Төлбөрийн актыг биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Монголиан бизнес рейтинг аудит ХХК-д ирүүлэхийг Монгол улсын далайн захиргааны дарга С.Түвшинтөр, нягтлан бодогч П.Мөнхбат нарт хариуцуулав.

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГААНЫ
ДАРГА

С.ТҮВШИНТӨР

НЯГТЛАН БОДОГЧ

П.МӨНХБАТ

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
"МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ АУДИТ"
ХХК-ИЙН АУДИТОР

Р.ЦАНЖИДМАА

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 18

№ 02/138

Улаанбаатар хот

СМ-2020/113/СТА-ТӨЧГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Монгол Улсын далайн захиргаа ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 58 дугаар тушаалаар баталсан Монгол Улсын далайн захиргааны 2019 оны орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан орлого тасарсан, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-ийн 1/3-д "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх алдаа, зөрчлийг арилгаж, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар анхаарч ажиллах.
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол улсын далайн захиргаа ТӨҮГ-ийн гүйцэтгэх захирал С.Түвшинтөр, нягтлан бодогч П.Мөнхбат нар т даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

АУДИТОР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
"МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ
АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Р.ЦАНЖИДМАА

ДАРГА

НЯГТЛАН БОДОГЧ

ЗӨВШӨӨРСӨН:

С.ТҮВШИНТӨР

П.МӨНХБАТ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

